



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/47

Улаанбаатар хот

Ажил сайжруулах удирдамж батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Газрын даргын 2022 оны А/14 дүгээр тушаал, Газрын даргын дэргэдэх удирдлагын зөвлөлийн 2022 оны 09 дүгээр хурлын тэмдэглэл, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх, газрын даргын 2022 оны А/40 дүгээр тушаалын дагуу хэлтсүүдийн үйл ажиллагаанд хийгдсэн дотоод хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, нэгдсэн арга хэмжээний удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх бодлогын баримт бичиг, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж үр дүнг газрын удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулахыг нийт хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-д даалгасугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ

1150500240